

Ж.Отгонбаяр
МУБИС

СУРАГЧДАД ФИЛОСОФИ ЗААХ РЕФЛЕКСИВ ЗАГВАРЫН ТУХАЙ

Түлхүүр үг: сургалтын рефлексив загвар, ухаалаг сэтгэлгээ, хариуцлагын мэдрэмж, үнэлэмж, сурагчдад зориулсан философи.

Сургалтын үйл ажиллагааны философи үндэслэлийн тухай

Би энэхүү нийтлэлдээ сургалтын практикт философиийн мэдлэгийг арга хэрэгсэл болгон ашиглах тухай асуудлыг хөндөж авч үзэхийг зорилго болгож байна. Энэ талаар өнөөгийн дэлхийн философиид чамгүй туршлага хэдийнээ хуримтлагдсан билээ.

Залуу хойч үеэ оюуны өндөр чадамжтай, ардчилал, зах зээлийн эрхэм дээд үнэт зүйлсийг өөриймшүүлэн цогцлоосон ухаалаг иргэд болгон төлөвшүүлэх явдал бол манай нийгмийн нэгэн нэн тулгамдсан асуудал билээ. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд сургалтын үйл ажиллагааг уламжлалт байдлаар, зөвхөн мэдээлэл дамжуулах хэлбэрээр эрхлэн хөтөлж ирсэн арга барил, загвар хүчин мөхөсдөж байна. Нөгөө талаас, Философиийг нийгэм хийгээд хүний амьдрал, үйл ажиллагаа, тэр тусмаа боловсрол, сургалтын практикт ойртуулж хэрэглэх нь зайлшгүй шаардлага юм.

Эдгээр эрэлт хэрэгцээг харилцан уулзуулж биелэл болгох нэг арга зам нь боловсрол, сургалтын үйл хэрэгт шинэ, рефлексив үйл ажиллагааг нэвтрүүлж хэрэглэх явдал байж болох юм. Судлаачид, философичдын олонтаа хэрэглэх болсон “рефлексив үйл ажиллагаа” хэмээх нэр томъёо нь олон талтай, гүн гүнзгий утгыг илэрхийлсэн, зарим талаараа болзмол шинжтэй байж болох ч, тухайн энэ тохиолдолд ухаалаг сэтгэлгээ, шүүмжлэлт эргэцүүлэлд тэмүүлж эрэлхийлсэн суралцагчийн идэвхтэй байр суурийг онцлон илэрхийлсэн ойлголт байдлаар хэрэглэж байна. Сургалтын үйл ажиллагааны хэм хэмжээ, дэг горим болсон энэхүү үйлдлийг сургалтын рефлексив загвар хэмээн нэрлэж буй билээ.

Сургалтын үйл ажиллагаанд рефлексив загварыг хэрэглэхэд хоёр хувилбар байж болох юм хэмээн би үзэж байна. Энэ нь нэгдүгээрт, Ерөнхий боловсролын сургуулийн бага ангиас нь эхлэн философиийн хичээлийг

судлагдхуун болгон заах явдал билээ. Хоёрдугаарт, бүх шатны сургалт, хичээлийг философиин арга хэрэгсэл (ойлголт, санаа, ерөнхийлөл, нэгтгэн дүгнэлт гэх мэт) ашиглан заах буюу хичээлийг нэгэн төрлийн философиодот болгон хувиргах явдал юм. Дашрамд тэмдэглэхэд, "философиодох", эсвэл "философи хийх" (doing philosophy, делать философию) гэдэг нэр томъёо мэргэжлийн хүрээнээс хэдийнээ хальж тодорхой утгатайгаар хэрэглэгдэх болсон юм.

Ерөнхий боловсолын сургуулийн дунд, ахлах ангийнханд байтугай, их, дээд сургуулийн оюутнуудад зааж ойлгуулахад ярвигтай байдаг философиийн ухааныг багаангийн сурагчдад зааж болохгүй мэтээр зарим хүмүүс эргэлзэж гайхдаг л даа. Шуудхан хэлэхэд, энэхүү эргэлзээ нь, нэг талаас философиийн тухай хуурмаг төсөөлөл, нөгөө талаас, багаангийн сурагчдын хийсвэр сэтгэлгээ доогуур төвшинд байдаг мэт өрөөсгөл төсөөлөлтэй холбоотой гэж үзэж байна. Нэг дэх төсөөлөл нь манай сургалтанд философиийг олон жилийн туршид марксист үзэл суртлаар "хүндрүүлж", амьдралаас тасархай, гаднаас тулгасан байдлаар зааж байсантай холбоотой. Манай боловсрол сургалтын философи нь ч ийм л байлаа шүү дээ. Харин хоёр дахь төсөөлөл нь манай сургалтын онол практикт өнө удаан оршин тогтнож хөдөлбөр, хуваарьгүйгээр ноёлж буй Ж. Пиажегийн (1896-1980) үзэл номлолтой холбоотой юм. Учир нь уг үзэл номлол ёсоор бол, хүүхдийн хийсвэр сэтгэлгээний төлөвшлийн үе шатыг 12-14 нас гэж заасан байдаг. Гэхдээ энэ бол Пиажегийн буруу гэхээсээ харин тухайн үзэл, онолыг нийгмийн хийгээд хувь хүний хөгжлийн хурдац, өнөөгийн нөхцөл байдалтай холбож ойлгохгүй байгаа бидний буруу юм. Өөрөөр хэлбэл, бид дунд сургуулийн сургалтын онол практикийг эргэн харж шинэ, орчин үеийн философи суурин дээр запруулга хийх ёстой гэсэн үг ээ. Энэхүү философиийн гол үзэл, цөм агуулга нь мөнөөх рефлексив үйл ажиллагаа байх учиртай хэмээн үзэж байгаа юм.

Ийм байдлаар авч үзвэл, орчин үеийн прагматик философи дээрх эргэлзээ, хуурамч ужиг төсөөлөлд хэдийнээ хариулт өгч, цэг тавьсан байна. Энэ тухай хойно өгүүльюу.

Хүүхэд, философи хоёр бол заяамал холбоотой андууд мөн

Хүүхэд бол төрөлхийн сониуч зантай, асуун шалгаасан, түвэгтэй бүхний учрыг олох гэсэн эцэж цуцашгүй эрэлчин, хайгуулчин байдаг. Харин философи нь адarmaатай бүхий л асуудлын зангилааны үзүүр болох олон

хувилбарт шийдлийг өөртөө агуулж байдаг. Эдгээр шинжүүд нь тэднийг заяаны холбоотнууд болгодог юм. Хүүхэд дөнгөж хэлд орж эхэлмэгцээ л “Энэ юу вэ? тэр юу вэ? Яагаад гэр доторх зайд нь дугуй, байшин доторх нь дөрвөлжин юм шиг байна вэ?”, “Тэнгэрийн гэр нь хаана байдаг юм бэ?”, “Хүмүүсийн зарим нь яагаад сайн, зарим нь яагаад муу байдаг вэ?”, “Би яагаад том хүн биш байна? Маргааш яагаад өнөөдөр биш байна?”, “Хөршийнх яагаад машинтай, манайх яагаад машингүй байна?”, “Аав ээжийг төрөхөөс өмнө би хаана байсан бэ?”, “Нас барсан гээд байгаа эмээ маань хаашаа явсан юм бэ?” гэхчилэнгийн түмэн янзын эцэс төгсгөлгүй асуултуудыг ээж аав болон ойр дотныхондоо тавьсаар байдаг бөгөөд төдийлөн баттай хариуг ч олж авч чаддаггүй.

Хүүхдийн байнга тавьдаг “Яагаад” хэмээх асуулт нь зөвхөн тухайн зүйлийн учир шалтгааныг тодруулах гэсэн каузаль шинжтэйгээс гадна, мөнхүү түүний үнэ цэнэ, утга учир, зорилго чиглэлийг нь мэдэх гэсэн үнэлэмжийн буюу аксиологи шинжийг агуулж байдаг. Энэ тухайд хэн ч үл маргах биз ээ.

Ийм оньсого мэт асуултуудынхаа хариулт, утга учрыг сургуульд элсэн суралцсанаар олж авах юм байна гэсэн битүү хатуухан итгэл хүүхдэд ямар нэгэн байдлаар бий болдог. Ингээд л түргэн том болж сургуульд орохын бөөн хүслэн болдог. Гэвч хүслэн болсон өнөөх сургуульдаа ороход хичээлийн хуваарийг баримтлах гэсэн хатуу дэг журам үйлчилж, чөлөөт асуулт ч үгүй болдог. Эхлээд уншиж, бодож, бичиж сур, дараа нь тийм маягийн асуултуудаа тавь гэсэн зарчим энд хэрэгжиж байдаг. Энэ байдлаас болоод хүүхэд өдөөлт өгөөд байсан өнөөх асуултуудаа “чухал биш зүйл”, “гэнэн асуулт” гэж бодон ичих болж, бодох ёсгүй, эргэцүүлэх ёсгүй сэдэв юм байна гэсэн болгоомжлол төрж, үл асуух, үл лавлах, үл сонирхох дархлаа үүсдэг. Өөрөөр хэлбэл, хүүхдийн өнөөх сониуч зан, эрэл хайгуулын сэтгэлгээ нь бөхөж эхэлдэг. Ийнхүү эрмэлзлэл хүсэлд нь хязгаарлалт бий болж, зарим сэдвүүд, нэн ялангуяа “амьдралын утга учрын тухай” асуудал бол сургуулийн орчинд яригдах учиргүй, хаалттай сэдвүүд болж хувирдаг ажээ. Чухамдаа энэ бол философиин чиглэлийн сэдэв билээ.

Ингэж сурагчдын “өөрийн хүслээр” суралцсанаар хүсэлд нь хязгаарлалт бий болж, зарим сэдвүүд, нэн ялангуяа “амьдралын утга учрын тухай” асуудал бол сургуулийн орчинд яригдах учиргүй, хаалттай сэдвүүд болж хувирдаг ажээ. Чухамдаа энэ бол философиин чиглэлийн сэдэв билээ.

сэтгэлгээнд нь ноёлох болж, сургалтын үйл явцад мэдлэг эзэмших гэдэг нь мэдээллийг механикаар хуриатлуулж цуглуулах үйлдэл болж хувирдаг. Ангих тусам энэ байдал зарим сургачдад улам лавширсаар сургууль, сургалтанд үл итгэх байдал болж хувирдаг. Өөрөөр хэлбэл, манай сургалт “сэтгэл зовоосон” асуудлын тухай биш, хичээлийн хуваарийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт болоод байна гэсэн үг. Чухам эндээс л манай өнөөгийн сургалт бодит амьдралаас тасарч, амьд бие хүнийг “гээж” эхэлдэг бөгөөд хүн, түүний амьдралын утга учиртай холбогдсон ухаалаг сэтгэлгээний талыг нь орхиж оюун санааны зөвхөн хийсвэр талыг нь баримжаалах болдог. Тэрхүү орхигдсон зүйл бол нийгмийн амьдралд бие хүний хөтөч нь болох учиртай түүний ухаалаг чанар, үнэлэмж, хүсэл зориг, итгэл үнэмшлийнх нь ертөнц юм. Энэхүү нөхцөл байдлаас хэрхэн гарах вэ?

Философийг дунд сургуулийн сургалтанд хэрэглэх тухай санаа өмнө үеийн сэтгэгчдээс эх сурвалжтай

Нөхцөл байдлыг ийнхүү үнэлэн дүгнэсэн явдал бол түүнээс гарах арга замыг тодорхой болгох үндэслэл болж буй юм. Нэг ёсондоо, эмчилгээ хийхийн тулд оношоо тогтоолоо гэсэн үг. Сургалтын үйл ажиллагаа бэрхшээлтэй тулгарч түүнийг даван туулах гэж оролдож буй нь зөвхөн өнөө үеийн ч асуудал биш, зөвхөн манай нийгмийн хувьд ч тийм байгаа юм биш ээ. Энэ тухайд хүн төрөлхтний хуриатлуулсан туршлага арвин баялаг билээ. Тэр тусмаа даянших үзэгдэл эрч хүчээ авч Дэлхийн хөгжил нэгэн голдрилд орж буй өнөөгийн ертөнцөд уг туршлага руу хандах нь бидний хувьд зайлшгүй шаардлага, бас аз завшаан гэж бодож байна.

Судлаачид, философичид, сурган хүмүүжүүлэгчид сургалтын үр дүнтэй арга хэрэгслийг эрж хайсаар нэгэн цагт математикийн ухаанд, дараа нь грек латин хэлэнд, мөн яруу илтгэх урлаг хийгээд логикийн шинжлэх ухаанд бүх горьдлого найдлагаа тавьж байлаа. Харин 20 дугаар зууны сүүлийн арав гаран жилд компьютерийн сургалтанд энэ үүргийг даалгаж байв. Эдгээр хичээлүүд сэтгэн бодохуйг хөгжүүлэх хэрэгсэл, хөшүүрэг болдог ч, түүний мөн чанар, нөөцийг бүх талаар нээх, бие даасан үнэт зүйлс, соёл, ёс суртхууны төлөвшил, чухамдаа, ухаалаг төлөвшил болоод нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагын ёс зүйтг бүрэн хангаж чадахгүй гэдэг нь одоо үед нэгэнт тодорхой болжээ.

Суралцагсдад мэдээлэл дамжуулахыг гол зүйлээ болгодог боловсролын дан ганц уламжлалт загвараас татгалзаж, ядаж түүний альтернатив хувилбар болгож, тэднийг сэтгэн бодохуйд сургах, сэтгэхүйн соёл болсон философийг эзэмшүүлэх гэсэн философичид, сурган хүмүүжүүлэгчдийн олон талт оролдлого, үйл ажиллагааны үр дүн дээрх асуултанд тодорхой хариулт өглөө. Энэ бол дунд сургуулийн сургалтанд философийн мэдлэгийг арга хэрэгсэл болгон ашиглаж болох төдийгүй, зайлшгүй шаардлагатай гэсэн шинжилгээ судалгааны дүгнэлт билээ. Сургалтын үйл ажиллагаан дахь мэдээлэл дамжуулах үйлдэл болон загвар үйлийн тодорхой үүрэг, ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байгаа ч, онолын хувьд нотлогдож, практикаар туршигдаж үр дүнтэй гэдгээ нэгэнт харуулсан ололт болох рефлексив сэтгэлгээг дээрх үйл ажиллагааны практикт давамгайлуулан хэрэглэх шаардлагатай л гэсэн үг. Эс тэгвэл манай сургалт өнөөдөр сэтгэн бодохуйгүй сургалт болж хоцрох нь ээ.

Философийн ухааныг онцолсны учир юу вэ? Нэгдүгээрт, эрт үеэс хүн төрөлхтний сэтгэлгээний өв болох философийн мэдлэгийн нийтлэг түгээмэл шинж нь дунд сургуулийн сургалтын хэрэглээ багатай, хичээл хоорондын уялдаа холбоо муутай, тасархай зураг шиг байдлыг даван туулж, түүнийг хүүхдийн ой ухаанд ойлгогдохуйц нэгдмэл утгатай, өөр хоорондоо учирзүйн холбоотой болгож өгөхөд орлуулж зүйрлэшгүй чухал үүрэгтэй. Чухам ийм ч учраас зөвхөн дунд сургуульд төдийгүй улам улам салбаржин төрөлжиж буй шинжлэх ухааны мэдлэгийг эзэмшигч хэн бүхэнд энэ нь холбоотой болоод байна.

Хоёрдугаарт, амьдралд хөл тавьж буй өсвөр үеийнхний хувьд философийн хичээлийн хүрээ нь хамгийн олон янзын асуудлыг багтааж болох бөгөөд түүний дотор ёс суртхууны болон амьдралын утга учрыг эрж хайсан асуудлыг урсгал байдлаар биш, зорилго чиглэлтэйгээр, тодорхой сэдвүүдэд багтаан хэлэлцэж өөрийн амьдралын чиглэлийг тодорхойлох боломж олгох юм. Гуравдугаарт, Философийн мэдлэг нь суралцагсдад амьдралынхаа чиг баримжааг тухайн газар нутаг, улс орны хүрээнд төдийгүй, үндэстний хийгээд шашин соёлын, мөн улс төрийн өвөрмөц ялгаа бүхий дэлхийн төвшинд хайж олоход нь тусламж болох билээ. Ийм боломж хэрэгсэл математик, түүх, хэл, уран зохиол, компьютерийн сургалт болон бусад аливаа хичээлд үгүй юм.

Дунд сургуулийн сургалтанд философиийг хэрэглэх тухай үзэл санаа нь цоо шинэ зүйл биш, өмнө үеэс улбаатай оролдлого гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Хүүхдийн тавьж шалгаадаг асуултууд нь грекийн философиийн "гэнэн" асуултууттай адил төстэй байдгийг философичид аль эрт ажиглаж мэджээ. Хүүхдийн оюуны эрэл хайгуулд нь тусlamж зайлшгүй хэрэгтэй байсаар байхад нийгэм, боловсролын зүгээс түүнд ухаалаг бусаар хандаж буй тухай, мэргэжлийн философиид хуримтлагдсан баялаг туршлагыг энд ашиглахгүй байгаа тухай санааг анхлан дэвшүүлэгчдийн нэг нь Ж.Ж.Руссо (1712-1778) байсан юм. Германы сонгодог философиийн ноён оргил гэгдэх Ф.Гегель (1770-1830) гимназид багшилсан туршилгадаа тулгуурлан шүүмжлэлт эргэцүүлэл хийхэд дөхөм байдаг өсвөр насанд нь философиийг судлуулж өхлэхийг ажил үүргийнхээ дагуу хаандаа зөвлөмж болгож байжээ. Францын гимназид философи зааж буй туршлагаас санаа аван Оросын гимназид түүнийг нэвтрүүлэх тухай санал гарч, энэ зорилгоор Лев Толстой хүүхдэд зориулсан ёс суртхууны өгүүллүүдээ бичиж байсан нь баримт билээ. Нийгэм, хүн төрөлхтний тухайн үеийн хөгжлийн үе шатны онцлог нь дээрх сэтгэгчдийн үзэл санаа түгэн дэлгэрэхэд хориг саад болсон байж болох ч, харин өнөөгийн даяншиж буй нэгдмэл хөгжлийн орчилд энэ нь өөрөө захиалга болоод байна гэсэн дүгнэлтийг би хийж байна. Хүний амьдрал өөрөө улам улам философииж байна гэдэгтэй маргах боломж мөн хумигдаж байна.

Философи, логик, сэтгэл судлалын элементүүдийг дунд сургуульд заах гэсэн оролдлого 20 дугаар зууны Орост хэдэнтээ гарч, хожим нь дунд ангийн сурагчдыг философиid хамруулах нэрийн дор хэрэг дээрээ оюун санааг нь үзэл суртлаар зэвсэглэж өгөхийн тулд ахлах ангийнханд "Нийгэм судлал" хэмээх хичээлийг 1960-аад оноос зохих сурх бичгийн дагуу оруулах болсон ажээ.. Манай улс ч энэ байдлыг "дүүгийн ёсоор" хуулбарлан авсан билээ.

Бид авах ёстой сургамж , хийх ёстой залруулга

Батлах шаардлагагүй, тунхаглалын шинжтэй санаануудад үндэслэн бичигдсэн дээрх сурх бичиг хүүхдийн оюун ухааныг сэргээх биш, харин ч царцаасан гэхэд хилсдэхгүй болов уу. Сэтгэн бодохуйд биш, тогтоон цээжлэхэд чиглэсэн ном хүүхдүүдийг философиid ойртуулах биш, харин түүнээс хөндийрүүлсэн билээ. Түүгээр ч үл барам, энэ байдал нь өмнөх системд мэргэжил эзэмшсэн, манай орны боловсролтой иргэдэд

философийн тухай сөрөг дүр төрх, ойлголт бий болоход үлэмж үүрэг гүйцэтгэсэн бөгөөд одоо ч гэсэн сэтгэлгээний тэрхүү хэв загварын инерци хүчтэй хэвээр байсаар байна. Зөв юмыг буруу хийнэ гэдэг эс хийснээс дор бололтой. Үүний гор нь болж монголчуудын шинэ сонголтын эхний жилүүдэд дунд сургуулийн сургалтын хөтөлбөрөөс философийн сэдэвчилсэн бүлэг "арчигдсан" билээ. Тэр ч байтугай нийгмийн тухай мэдлэгийн хичээл ч дэн дундаа тулж байсан юм. Энэ бол бас л нэгэн төрлийн синдром өвчин байв. Ийм байдал үүсэхэд тухайн үед боловсролын салбарыг удирдаж байсан хүмүүсийн ухааны цараа ядуу, төр засгийн дээд албаныханд нийгмийн хөгжлийн талаарх сэтгэлгээ дулимаг, үндсэндээ технократ арга барилаар асуудалд хандаж байсан явдал хүчтэй нөлөөлсөн юм. Одоо ч гэсэн Их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт орж буй философийн хичээлийн цөөн хэдэн цагийг цалин мөнгө, цагийн норматив гэдгээр дулдуйдан хасаж үгүй хийхийг санаархдаг удирдлага цөөн биш ээ. Энэ бол монголын философийн боловсролын бодит байдал юм.

Хэрвээ бид нэгэн жаран илүү хугацаанд ханьсаж, даган дууриаж байсан улс орноо эргэн харах юм бол дунд сургуульд нь логикийн хичээлийг зааж, "Сурагчдад зориулсан философийн" олон улсын хөтөлбөрт нэгдэн практикт хэрэгжүүлж буйн зэрэгцээ сүүлийн 10 жилийн туршид Бүх Оросын философийн конгресс бүр дээр энэ асуудлыг тусгайлан авч хэлэлцдэг уламжлал тогтоод байна. Өөрөөр хэлбэл, философийг хэтэрхий өрөөсгөл байдлаар, анги намын шинжтэйгээр сурталдаж, хүн ардынхаа оюун сэтгэлгээнд учруулсан үйл нүглээ наманчилж залруулга хийснээр энэ орны хувьд ханш нь унаад байсан философийн мэргэжил эрэлт болон өндийлөө. Ийнхүү философийг үзэл сурталжсан чиг үүргээс нь бүрэн чөлөөлж, хүн төрөлхтний сэтгэхүйн соёл болох утгаар нь өргөн дэлгэр ашиглан хөгжүүлж байна.

Тэгвэл хөгжил дэвшлийн баримжаа болгон бидний жишээлэх дуртай Өрнөдийн орнууд, түүний дотор Нэгдсэн улсын хувьд байдал ямар байна вэ? Энэ Гүрэнт улс хөгжил дэвшлийнхээ гол баталгаа, үндсэн баялаг бол ардчиллын үнэт зүйлсийг өөртөө цогцлоосон эрх чөлөөт, ухаалаг иргэн хүн хэмээн үзэж, түүний боловсрол, хөгжилд тэргүүн зэргийн ач холбогдол өгч байна. Харин энэхүү боловсрол, сургалтынх нь суурь үзэл баримтлал бол

Джон Дьюи (1859-1952) тэргүүтэй философичдын боловсруулсан инструменталист (мэдлэгийг арга хэрэгсэл болгон ашигладаг) арга зүй билээ.

Сургалтын рефлексив загварын гол зарчмууд

Энэхүү нийтлэлийн гол сэдэв болоод буй сургалтын рефлексив, философи загвар чухамхүү дээрх арга зүйд үндэслэгдэн боловсорсныг тэмдэглэж байна. Сургалтын шинэ загварын философи баримтлалыг тухайн үедээ Колумбын их сургуулийн философиийн багш байсан профессор М.Липман тэргүүтэй хэсэг философичид, сурган хүмүүжүүлэх ухааны онолчид Боловсролын чиглэлээр явуулсан олон жилийн туршилт судалгааны үр дүнд Дж.Дьюи, Карл Поппер нарын үзэл баримтлалтай харьцуулан боловсруулжээ. Энэхүү шинэ үзэл баримтлалын гол зорилго нь боловсролын үламжлалт загварт орхигдоод буй сэтгэлгээний ухаалаг хэмээн тодотгож болох хэв шинжийг философиийн арга хэрэгслийн тусламжтайгаар төлөвшүүлэх явдал юм.

Сэтгэлгээний ийм хэв шинжийг түүний үндэслэлтэй, логик эрэмбэтэй, шүүмжлэлтэй, бүтээлч шинж чанар, мөнхүү ёс суртахууны ардчилсан дүр төрхтэй, үүрэг хариуцлагын мэдрэмжтэй, үнэлээмж үнэт зүйлсийн баримжаатай байдал нь тодорхойлох юм. Энэ үзэл баримтлалын гол зарчмуудыг дараахь байдлаар хураангуйлан илэрхийлж болно.

Нэгдүгээрт, Сургалтын гол арга хэлбэр нь философидолт мөн. Сурагчдад философиийн тухай мэдээлэл өгөхдөө гол нь бус, харин тэднийг философидолтонд сургах нь чухал. Тэд Сократын диалогийн аргаар философи хийж (*doing philosophy*, делать философию), философи ярилцах урлагт суралцах учиртай.

Хоёрдугаарт, Хувь хүн ба нийгмийн тулгамдсан асуудал, адarmaатай нөхцөлийг шийдвэрлэх байдлаар философиийн мэдлэгийг эзэмшүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, аливаа асуудал, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шийдэл гаргахдаа аль болох цогц бүхэл байдлаар нь авч үзэх, аль болох өндөр дээд төвшинд нь буюу философиийн мэдлэгт тулгуурлан хандах чадамжийг эзэмшүүлнэ гэсэн үг.

Гуравдугаарт, хичээл, сургалт бол судалгаа мөн. Анги бол судлаачдын бүлэг мөн хэмээх зарчим юм. Мэдлэг гэдэг нь багшаас шавь руу бэлнээр дамжиж өгөгддөг зүйл огт биш, харин судлаач-сургач түүнийг бүтээж бий болгодог. Энэ нь өнөөгийн манай боловсрол сургалтанд хүчтэй яригдаж буй

конструтивизмын үзэл санаа юм. Уг сурвалжийг нь хөөж үзвэл өнгөрсөн зууны жар, далаад онд төлөвшөн байх аж. Өөрөөр хэлбэл, сурагчдад шинжлэх ухааны бэлэн дүгнэлтүүд өгөх биш, тэднийг байнгын эрэл хайгуулын нөхцөлд байлгаж, өөрийнхөө байр суурийг илэрхийлэх, ойлголтын зөрүүгээ бусадтайгаа хэлэлцэх, засаж залруулах, таамаглалаа баталгаажуулж шинэ таамаг дэвшиүүлэх замаар дүгнэлтэнд өөрсдөө хүрэх боломжийг тэдэнд олгон ангийг судлаачдын баг, хамтлаг болгон зохион байгуулах явдал юм.

Дөрөвдүгээрт, багш бол эцсийн үнэнийг айлдагч “шүүгч” биш, харин судлаачдын бүлгийн хамтран оролцогч, чиглүүлэгч, дөхүүлэгч, менежер байх явдал юм. Багш, сурагчид тойрон өөд өөдөөсөө, нүүр нүүрээ харан суугаад, тэгш эрхтэйгээр, хүндэтгэл, соёлтойгоор мэтгэлцэн судалж үнэн мэдлэг рүү тэмүүлдэг байх юм.

Тавдугаарт, философиин онолын сурах бичгийн оронд хүүхдэд ойлгогдохуйц эргэцүүлэл бясалгал шаардсан, энгийнээс алхам алхмаар нарийсч гүнзгийрсэн өгүүллэг, эссе, зохиомж, найруулалт гэх мэт философи утга холбогдол бүхий бичлэгийн олон төрлийг ашиглах явдал юм. Энэхүү үзэл баримтлалыг үндэслэгчид сурагчдын нас сэтгэхүйн онцлогийг харгалзан үлгэр загвар болгон зохиосон философиийн өгүүлэл, нийтлэлүүддээ хүмүүс хоорондын харилцааны хэм хэмжээ, үнэлэмж, ойлголт, бодомж, логик гаргалгаа, эргэцүүлэл, оюун дүгнэлт, уг, түүний утга ба утгат чанар зэргийн ач холбогдлыг ихэд онцолсон байдаг юм.

Эдгээр зарчмуудаас харахад ч гэсэн хэл болон сэтгэн бодохуй хэмээх энэ хоёр хүчирхэг хэрэгслийг танин мэдэхүйн үйл ажиллагаанд үр дүнтэй, олон талтайгаар ашиглах явдал хичнээн чухал гэдэг нь ойлгомжтой байна. Тэр ч байтугай 6-9 наснаас философиийг эхлэн заах, тэгэхдээ бүр хэл, сэтгэхүйн тухай эргэцүүллээс эхлэхийг тэд санал болгожээ. Ингэж философиийг заасан ангийн сурагчдын сурлагын үзүүлэлт заагаагүй ангийнхнаас хэл бичгийн хувьд 36 хувиар, математикийн хувьд 66 хувиар дээгүүр байсан судалгааны дүн гарсан байдаг.

Мэдээж хэрэг, бид ийм байдалд хүрэхэд олон хүчин зүйл нөлөөлөх нь ойлгомжтой. Гэхдээ хамгийн гол нь та бидний хүсэл зориг, итгэл үэмшил, ёс суртахуун, хариуцлагын мэдрэмж гэж үзэж байна.

М.Липман нар энэхүү үзэл баримтлалдаа тулгуурлан “Сурагчдад зориулсан философи” (“Philosophy for children”, “Философия для детей”) хэмээх

хөтөлбөрийг боловсруулжээ. Үүссэн даруйдаа Дэлхийн 20 гаруй оронд дэлгэрч, 15 хэлэнд орчуулагдаж байсан энэ хөтөлбөр нь Боловсролын чиглэлийн олон улсын нэр хүнд бүхий байгууллага (ЮНЕСКО, Европын Парламентын боловсролын комисс, АНУ-ын Боловсролын яам)-аас өндөр үнэлгээ авсан бөгөөд хорь гаран жилийн хугацаанд янз бүрийн улс оронд туршигдан хэрэгжихдээ засал сайжралыг олсоор одоо нэгэнт нэр хүнд нь тогтжээ. Энэ хөтөлбөрийн өндөр амжилт олж буй үндсийг М.Липман тайлбарлахдаа аливаа соёлын орчинд өөрчлөн зохицуулж, засварлан хэрэглэж болохуйц нээлттэй байдагт оршино хэмээн К.Попперын томъёоллоор гол санаагаа илэрхийлсэн байдаг.

Уг хөтөлбөрийн агуулга нь дунд сургуулийн сургалтын үйл ажиллагааны хүрээнээс хэдийнээ хальж, нийт багш сурган хүмүүжүүлэгчид, философичдын арга барил болон хувирч, оюутан залуус, философиин онол судлаачдад хамаатай болж их, дээд сургууль, коллежийн танхimuудад нэгэнт хэрэгжиж эхэлжээ. Товчоор хэлбэл, уг хөтөлбөрийн онол арга зүйн судалгаа нь их, дээд сургуулийн төвшинд хүрч өргөн цар хүрээтэй болон боловсролын зарчмуудыг бүхэлд нь хөндөх болсон байна. Тийм ч учраас өнөөдөр энэ хөтөлбөрийн үзэл санааг сургалтын төдийгүй, мөн орчин цагийн боловсролын нэгэн чухал философи үндэслэл мөн хэмээн судлаачид, философичид үзэж байна.

Жич: Дашрамд хэлэхэд, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн нийгмийн ухааны багш бид нар уг хөтөлбөрийн үзэл санаа, агуулга, арга зүйн талаар бичигдсэн "Сурагчдад зориулсан философи" хэмээх номыг орос хэлнээс орчуулж хэвлэлд бэлтгэж буйгаа Та бүхэнд дуулгахад таатай байна.

Хэрвээ та энд хөндсөн сэдвээр бидэнтэй санал бодлоо солилцохыг хүсвэл ажлын хаягаар уулзахын зэрэгцээ Khuldjo@yahoo.com электрон шуудангаар харилцаарай.

Резюме

В данной статье речь шла о рефлексивной модели обучения, суть которой заключается в том, чтобы преподавать философию в средних школах, начиная с младших классов. Автор считает, что это не только возможно, но и необходимо. По его мнению дети и философия являются естественными союзниками. Он критикует традиционную информационную модель обучения за то, что она в основном направлена на передачу рациональных знаний в готовом виде, потеряя и самого учащегося, и его активность, и его разумность, и его

ценностный мир в целом. В результате такой оторванности от реальной жизни появляется обучение, которое никак не отвечает на заказ современного общества. Обращаясь на накопленный в мировой философии богатый опыт, автор рассматривает необходимым использовать философские средства (понятия, идеи, обобщение, рефлексия и т.д) для обучения. Философское обучение должно быть не авторитарной доктриной, а настоящим философствованием, осуществляющимся по образцу сократова диалога. В то же время вместо теоретического учебника он предлагает философски насыщенные художественные тексты, эссе, подходящие возрастным особенностям учащихся. Далее он подчеркивает значимость основанной на рефлексивной модели международной программы "Философия для детей", создателями которой является профессор М.Липман и его коллеги.

Ашигласан ном, материал

- 1.Юлина Н. С Философия для детей М., 1996
- 2.Lipman, Matthew. (1991), Thinking in Education. Cambridge Univ. Press
3. Lipman, Matthew (1988) Philosophy Goes to School. Philadelphia, Temple University Press
- 4.Karin Murris Can Children do Philosophy.